



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шатны төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/127/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663      Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 261885      Цахим хаяг: <a href="mailto:enkhdalai.d@audit.gov.mn">enkhdalai.d@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Ж.Мөнхбилгүүн Утас: 261740      Цахим хаяг: <a href="mailto:munkhbilguun.j@audit.gov.mn">munkhbilguun.j@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Сүлд-Аудит" ХХК-ийн захирал: Ч.Гүндбаяр Утас: 70118016      Цахим хаяг: <a href="mailto:info@suld-audit.mn">info@suld-audit.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

БҮС НУТГИЙН АВТО ЗАМЫГ  
ХӨГЖҮҮЛЭХ, ЗАСВАР АРЧЛАЛТЫН  
3 ДУГААР ҮЕ ШАТНЫ ТӨСЛИЙН  
ЗАХИРАЛ Г.БАТБАЯР ТАНАА

2025.03.20 № 07/1101  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шатны төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шатны төслийг хэрэгжүүлэхээр Монгол Улс болон Азийн Хөгжлийн банкны хооронд 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр хөнгөлөлттэй зээлийн 30.0 сая ам.доллар, энгийн зээлийн 120.0 сая ам.долларын гэрээ байгуулагдаж, төслийн үйл ажиллагааг 2024 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна. Төслийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто зам;
- Улиастай-Алтай чиглэлийн 178 км хатуу хучилттай авто зам;
- Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй авто замын хөрөнгийн менежментийн тогтолцоог сайжруулах зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэх сургалтын төлөвлөгөөг боловсруулах ажил;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх журам боловсруулах чиглэлээр сургалтын материалыг боловсруулах ажил;
- А0305 улсын чанартай Ховд – Баян-Өлгий чиглэлийн авто замаас Эрдэнэбүрэн сум чиглэлийн 19.776 км авто замын ажил;
- А0305 улсын чанартай Ховд – Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн 18.755 км авто замын ажил.

## Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус төслийн нэгж нь Зам, тээврийн яамны 2024 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн албан бичгийн дагуу "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл 2"-оос А0305 улсын чанартай Ховд-Баян-Өлгий чиглэлийн авто замаас Эрдэнэбүрэн сум чиглэлийн 19.776 км авто зам, А0305 улсын чанартай Ховд-Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн 18.755 км авто замын ажлуудыг 2024 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр Зам тээврийн яамнаас акт үйлдэн хүлээн авсан байна. Эрдэнэбүрэн, Ховд чиглэлийн авто зам барих ажлын гүйцэтгэл 95.5 хувьтай, тайлант онд 1,854,051.5 мянган төгрөгийн санхүүжилт гарсан байна.

## Бусад асуудлын хэсэг

Тус төсөл нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>10,558,202,405.36</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		8,677,420,615.35
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>		<b>8,677,420,615.35</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>		<b>136,087,955.76</b>
31211	Төрийн сангийн харилцах		136,087,955.76
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>		<b>8,541,332,659.59</b>
31221	Төрийн сангийн харилцах		8,541,332,659.59
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		<b>514,250.01</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		462,825.01
<b>335</b>	<b>БУСАД АВЛАГА</b>		51,425.00
3351	Байгууллагаас авах авлага		<b>51,425.00</b>
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>		<b>6,216,000.00</b>
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>		<b>6,216,000.00</b>
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа		6,216,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		<b>20,000,000.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		<b>20,000,000.00</b>
35440	Түлш, шатах тослох материал		20,000,000.00
<b>36</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		<b>1,854,051,540.00</b>
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/		1,854,051,540.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>88,394,655.56</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		<b>88,394,655.56</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		<b>84,434,655.56</b>
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		85,110,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(675,444.44)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		<b>3,960,000.00</b>
39301	Програм хангамж		3,960,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>10,646,597,060.92</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>2,514,318.19</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>2,514,318.19</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>		<b>2,514,318.19</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		2,514,318.19
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>10,644,082,742.73</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		<b>10,644,082,742.73</b>
51210	Өмнөх үеийн үр дүн		
51220	Тайлант үеийн үр дүн		10,644,082,742.73
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>10,646,597,060.92</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>10,880,886,035.36</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>10,880,886,035.36</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>10,880,886,035.36</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>		<b>10,880,886,035.36</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		10,880,886,035.36
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>268,195,463.65</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>268,195,463.65</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>268,195,463.65</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>211,919,893.94</b>
210101	Үндсэн цалин		211,919,893.94
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>23,866,486.75</b>
210201	Тэтгэврийн даатгал		23,866,486.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>21,600,000.00</b>
210304	Байрны түрээс		21,600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>6,736,058.77</b>
210401	Бичиг хэрэг		4,992,130.00
210402	Тээвэр, шатахуун		5,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,738,208.77
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>100,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		100,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>3,212,340.00</b>
210702	Дотоод албан томилолт		3,212,340.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>85,239.75</b>
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		85,239.75
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>675,444.44</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		675,444.44
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>		<b>10,612,690,571.71</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		<b>31,392,174.84</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		31,392,174.84
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>3.82</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		3.82
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>		<b>31,392,171.02</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>		<b>10,644,082,742.73</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>		<b>10,880,886,035.36</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>10,880,886,035.36</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>10,880,886,035.36</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>		<b>10,880,886,035.36</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		10,880,886,035.36
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>		<b>295,695,951.03</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>295,695,951.03</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>295,695,951.03</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>211,207,939.40</b>
210101	Үндсэн цалин		211,207,939.40
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>22,578,373.11</b>
210201	Тэтгэврийн даатгал		16,200,562.73
210202	Тэтгэмжийн даатгал		1,806,269.85
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,300,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал		654,308.11
210205	Эрүүл мэндийн даатгал		2,617,232.42
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>21,600,000.00</b>
210304	Байрны түрээс		21,600,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>30,696,058.77</b>
210401	Бичиг хэрэг		4,992,130.00
210402	Тээвэр, шатахуун		20,005,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		5,698,208.77
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>6,316,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		100,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		6,216,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>3,212,340.00</b>
210702	Дотоод албан томилолт		3,212,340.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>85,239.75</b>
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		85,239.75
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>		<b>10,585,190,084.33</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		<b>1,939,161,640.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>1,939,161,640.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>1,939,161,640.00</b>
220001	Барилга байгууламж		1,854,051,540.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		85,110,100.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		<b>(1,939,161,640.00)</b>
14	<b>Бусад эх үүсвэр</b>		<b>31,392,174.84</b>
145004	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		31,392,174.84
25	<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>		<b>3.82</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүү		3.82
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		<b>31,392,171.02</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		<b>8,677,420,615.35</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>-</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>8,677,420,615.35</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-		
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-		
Тайлант үеийн үр дүн	-	10,644,082,742.73	10,644,082,742.73
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>10,644,082,742.73</b>	<b>10,644,082,742.73</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,915,645,500.00</b>	<b>2,234,772,351.28</b>	<b>680,873,148.72</b>	<b>76.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>515,645,500.00</b>	<b>380,720,811.28</b>	<b>134,924,688.72</b>	<b>73.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>515,645,500.00</b>	<b>380,720,811.28</b>	<b>134,924,688.72</b>	<b>73.8</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>260,000,000.00</b>	<b>211,207,939.40</b>	<b>48,792,060.60</b>	<b>81.2</b>
210101	Үндсэн цалин	260,000,000.00	211,207,939.40	48,792,060.60	81.2
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>32,500,000.00</b>	<b>22,578,373.11</b>	<b>9,921,626.89</b>	<b>69.5</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,100,000.00	16,200,562.73	5,899,437.27	73.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,600,000.00	1,806,269.85	793,730.15	69.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,300,000.00	1,300,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,300,000.00	654,308.11	645,691.89	50.3
210205	Эрүүл мэндийн даатгал	5,200,000.00	2,617,232.42	2,582,767.58	50.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,500,000.00</b>	<b>21,600,000.00</b>	<b>7,900,000.00</b>	<b>73.2</b>
210304	Байрны түрээс	29,500,000.00	21,600,000.00	7,900,000.00	73.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>45,109,200.00</b>	<b>30,696,058.77</b>	<b>14,413,141.23</b>	<b>68.0</b>
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	4,992,130.00	7,870.00	99.8
210402	Тээвэр, шатахуун	31,358,200.00	20,005,720.00	11,352,480.00	63.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,751,000.00	5,698,208.77	3,052,791.23	65.1
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>135,956,300.00</b>	<b>91,426,100.00</b>	<b>44,530,200.00</b>	<b>67.2</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	90,371,000.00	85,210,100.00	5,160,900.00	94.3
210602	Тавилга	39,369,300.00		39,369,300.00	0.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,216,000.00	6,216,000.00	-	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>12,580,000.00</b>	<b>3,212,340.00</b>	<b>9,367,660.00</b>	<b>25.5</b>
210702	Дотоод албан томилолт	12,580,000.00	3,212,340.00	9,367,660.00	25.5
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,400,000,000.00</b>	<b>1,854,051,540.00</b>	<b>545,948,460.00</b>	<b>77.3</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,400,000,000.00</b>	<b>1,854,051,540.00</b>	<b>545,948,460.00</b>	<b>77.3</b>
220001	Барилга байгууламж	2,400,000,000.00	1,854,051,540.00	545,948,460.00	77.3
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,915,645,500.00</b>	<b>2,370,860,307.04</b>	<b>544,785,192.96</b>	<b>81.3</b>
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>2,915,645,500.00</b>	<b>2,370,860,307.04</b>	<b>544,785,192.96</b>	<b>81.3</b>
122002	Хандив тусламж /гадаад/	2,915,645,500.00	2,370,860,307.04	544,785,192.96	81.3
	<b>Төсвийн гүйцэтгэлийн тохируулга</b>		<b>8,541,332,659.59</b>		
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			-	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		8,677,420,615.35		
<b>6</b>	<b>Төсвийн бусад мэдээлэл</b>				
<b>62</b>	<b>Ажиллагсадын тоо</b>	<b>9</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>77.8</b>
62001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
62002	Гүйцэтгэх ажилтан	8	6	2	75.0

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шатны төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 8,572,724.8 мянган төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Валютын ханшийн зөрүүний олзыг ангилал зөрүүлж тайлагнасан	1	31,392.2			1	31,392.2	1	31,392.2				
Төсвийн гүйцэтгэлийн тайлан алдаатай илэрхийлэгдсэн	1	8,541,332.6			1	8,541,332.6	1	8,541,332.6				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>8,572,724.8</b>			<b>2</b>	<b>8,572,724.8</b>	<b>2</b>	<b>8,572,724.8</b>				

3.2 Аудитаар илэрсэн нийт 3,216.0 мянган төгрөгийн зөрчилд<sup>2</sup> 1 төлбөрийн акт тогтоолоо.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Тайлант онд ажилчдын хувцас худалдан авахаар 3,216.0 мянган төгрөг “Асралт баян хайрхан” ХХК-руу шилжүүлсэн боловч хүлээн авсан нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.	1	3,216.0	1	3,216.0									
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,216.0</b>	<b>1</b>	<b>3,216.0</b>									

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.